MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Global Affairs Canada
Affaires mondiales Canada

Харилцан хамаарал бүхий хүн ам, нийгмийн үзүүлэлтүүд

Агуулга

Хүнийг тодорхойлогч хүчин зүйлс

Шашин шүтлэг

Үндэс угсаа, гарал үүсэл

Нас

Бэлгийн чиг баримжаа

Хөгжлийн бэрхшээлтэй эсэх

Бусад

Хүнийг тодорхойлогч хүчин зүйлс

- Биднийг хэн гэдгийг тодорхойлдог харилцан хамаарал бүхий өөр өөр олон хүчин зүйл байдаг. Үүнийг “харилцан хамаарал бүхий хүн ам, нийгмийн үзүүлэлтүүд” /intersectionality/ гэж нэрлэдэг.
- Жендэрийн дүн шинжилгээ нь хүйс ба жендэрээр хязгаарлагддаггүй. Үүнд бусад хүн ам, нийгмийн үзүүлэлт болох үндэс угсаа, гарал үүсэл, шашин шүтлэг, нас, оюун санааны болон бие махбодийн хөгжлийн бэрхшээлтэй эсэх нь хэрхэн харилцан хамаарч, нөлөөлж байна вэ гэдгийг авч үздэг.

Шашин шүтлэг

- Шашин бол зарим хүнийг тодорхойлдог гол хүчин зүйл болдог.
- Шашин гэдэг үг нь “хамтад нь уях буюу холбох" гэсэн утгатай латин үгнээс гаралтай.
- Толь бичигт үүнийг "оршин байгаа эсвэл ер бусын зүйлийг шүтэх итгэл үнэмшил, зан үйлийн зохион байгуулалттай тогтолцоо" гэж тодорхойлсон байдаг.
- Аливаа шашин шүтэх нь итгэл үнэмшлээ хуваалцах, зан үйлд оролцохоос илүүтэйгээр нийгмийн нэг хэсэг, заримдаа соёлын нэгээхэн хэсэг болох талтай байдаг.

Үндэс угсаа

- Үндэс угсаа нь тодорхой бүлэг хүмүүсийн хооронд ын харилцааны орчил юм. Энэ нь янз бүрийн байдлаар нөлөөлдөг түүх, газарзүй, биологийн нөхцөлөөс улбаатай.

Гарал үүсэл

- Арван долдугаар зуунаас үүсэлтэй нийгмийг анги давхаргад хуваах үзэгдэл юм. Энэ нь “арьсны өнгө”-тэй адил ойлголт бөгөөд АНУ-д удаан хугацааны турш хүнийг тодорхойлох гол эх сурвалж болжээ.

Бэлгийн чиг баримжаа

- Бэлгийн чиг баримжаа нь таныг хэнд татагддаг, хэнтэй харьцаанд орох хүсэлтэй байгааг илэрхийлэх ойлголт. Бэлгийн чиг баримжаанд гей, лесбиян, эсрэг хүйстнээ сонирхогч, бисексуал, бэлгийн харилцаанд оролцох сонирхолгүй зэрэг ордог. Олон хүний хувьд энэ нь хэн болохыг нь тодорхойлох гол зүйл байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй эсэх

- Хөгжлийн бэрхшээл нь хувь хүнийг заримдаа ялгаварлал, гадуурхалт, алагчлалд өртөмтгий цөөнхийн бүлэгт багтахад хүргэдэг тусгай хүчин зүйл юм.

Боловсрол

- Хүний өөрийгөө тодорхойлох байдал болон боловсрол нь хоорондоо нягт уялдаатай.
- Боловсрол нь суралцаж буй хүнийг хэн болохыг тодорхойлдог хүчин зүйл.
- Боловсролоор дамжуулан хүн өөртөө давуу талыг бий болгож чадна.
- Боловсролын түвшин доогуур иргэд өөрсдийгөө дорд үзэж, доогуур үнэлэх хандлагатай байдаг.

Орлого

- Мөнгө хүмүүсийн өдөр тутмын амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг хэрэгсэл.
- Хүмүүс юуг, яагаад худалдаж авдаг, мөнгөний талаар ярьдаг эсэх болон хэнд ярьдаг нь тэднийг ямар хүн болохыг тодорхойлдог.
- Хүмүүс мөнгөгүй эсвэл элбэг хангалуун байх нь тэдний биеэ авч явах болон төрийн бодлого тэдэнд хэрхэн нөлөөлөх байдалд шууд нөлөөлдөг ~~байна~~.

Соёл

- Соёл бол тухайн бүлэгт хамаарах тодорхойлолт, эсвэл мэдрэмж юм.
- Тухайн хүн өөрийгөө таньж мэдэх, үзэх үзлийн нэг хэсэг бөгөөд өөрийн гэсэн өвөрмөц соёл бүхий нийгмийн аль нэг бүлэг, эсвэл үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн анги давхарга, үе, нутаг устай холбоотой байдаг.

Газарзүйн байршил (хот/хөдөө)

- Газарзүйн байршил нь бидний сонгож авсан мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагаа, хоол тэжээл, хүмүүсийн харилцаанд хүртэл нөлөөлдөг.
- Газарзүй нь хувь хүнийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Амьдарч буй бүс нутаг, уур амьсгалын нөхцөлөөс шалтгаалан тухайн хүний өөрийн тодорхойлолт төлөвшдөг.
- Амьдралын талаарх үзэл бодол, тэдний үнэт зүйлс, хүлээлт газарзүйн нөхцөл байдлаас хамаардаг.

MERIT
A CESO AND WUSC PROGRAM

Global Affairs Canada
Affaires mondiales Canada

Баярлалаа.